

**ӨМӨЗО-ы Хөлөнбуйр хотод буй
монгол төрөл хэл хийгээд манж-түнгүс төрөл хэл,
тэдгээрийн аялгуунуудын тойм байдал**

ЦЭРЭНБАТ*

БНХАУ-ын ӨМӨЗО, Хөлөнбуйр хот, Хайлаар тойрог, Хөлөнбуйр Их Сургууль

Гэрэлт-Одын БАТЗАЯА

*Монгол Улс, Улаанбаатар хот, Шинжлэх Ухааны Академи,
Хэл зохиолын хүрээлэн, Хэл шинжлэлийн салбар*

Received: 18 September 2025 / **Accepted:** 28 September 2025 / **Published:** 30 December 2025

Хураангуй: БНХАУ-д 56 үндэстний хүмүүс оришин суудгаас ӨМӨЗО-ы Хөлөнбуйр хотод 42 үндэстэн аж төрдөг. Тэдгээрийн дотор монгол ба манж-түнгүүс үндэстнүүд бий. Тэдний хэлнүүд нь монгол төрөл – өмнөд монгол болон дагуур хэл, манж-түнгүүс төрөл – эвенк болон орчоон хэл юм. Тэд бүгд алтай язгуурын хэлнүүд учраас өөр хоорондоо тодорхой хэмжээгээр ижил төстэй. Эдгээр хэл өөр хоорондоо адилсах явдал ч түгээмэл. Гэвч өдгөө бүгд хятад хэлний нөлөөг хүртэж, зарим хэсэг нь уугуул хэлээ мартаж, ялангуяа хүүхэд залуус нь хятад хэлтэн болж байна. Тухайлбал, орчоон хэл устаж мөхөх шатандаа орсон байна. Нөгөө талаас, урт удаан хугацаанд энэхүү нутаг усанд бусад үндэстэнтэй холилдон амьдарсан боловч өөрийн хэл, аялгууныхаа онцлог шинжийг өнөө хэр ямар нэг хэмжээгээр хадгалж буй хүмүүс бас байна. Тухайлбал өөлд хүмүүс цөөхөн, хэл яриа нь мөн л бусад хэл, аялгуунд ууссан зүйл олон байвч өнөө хэр бусдаасаа ямар нэг байдлаар заавал ялгарч мэдэгддэг. Харин эдгээрээс зарим аялгууны талаарх судалгаа хангалттай биш байна. Тэдний нөхцөл байдал, аялгууны үндсэн шинжээс өнөө хүртэл уламжилж үлдсэн зүйлсийг сонирхон судалбал монгол хэл шинжлэлд үнэ цэнтэй материал болох юм.

Түлхүүр үгс: Хөлөнбуйр, монгол төрөл хэл (өмнөд монгол хэл, дагуур хэл), манж-түнгүүс төрөл хэл (эвенк хэл, орчоон хэл)

**The Status of the
Mongolian and Manch-Tunguz Languages
in Kholenbuir City of Inner Mongolia**

TSERENBAT

*Hulunbuir University,
Khailar district, Hulunbuir city, Inner Mongolia, China*

BATZAYA Gerelt-Od

*Department of Linguistics, Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia*

* © Author(s), 2025, Email: srbt081@126.com



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

Abstract: *In Hulunbuir City of the Inner Mongolia Autonomous Region of the People's Republic of China, the resident ethnic groups include Mongolic and Manchu-Tungusic peoples. Their languages comprise the Mongolic related languages – South Mongolian and Dagur. Manchu-Tungusic related languages – Evenki and Orchon. As all of these languages are classified within the Altaic family, they display a certain degree of structural and lexical similarity. Processes of language convergence and mutual borrowing are also widely attested. At present, however, all of these languages are undergoing significant language shift under the influence of Chinese. In many cases, especially among younger generations, the dominant use of Chinese has led to attrition of the heritage languages. Orchon, in particular, is critically endangered and on the verge of extinction. Nevertheless, despite long-term interethnic contact and assimilation in this region, some groups continue to preserve distinctive phonological and lexical features of their own speech varieties. For example, although the Ööld population is numerically small and their speech has undergone extensive influence from neighboring languages and dialects, they still maintain certain features that mark them as linguistically distinct.*

Key words: *Khulunbuir, Mongolian Languages (South Mongolian, Dagur Language), Manchurian-Tungus Languages (Evenki Language, Orchon Language)*

1. Удиртгал

Бүгд Найрамдах Хятад Ард Улс нь 56 үндэстнийг багтаасан гүрэн юм. Харин ӨМӨЗО-ы Хөлөнбуйр хотод 42 үндэстэн аж төрдөг. Түүний дотор алтай язгуурын хэлтнүүд бий. Үүнд: монгол төрлийн хэлтэй монгол үндэстэн, дагуур үндэстэн, манж-түнгүүс төрлийн хэлтэй эвенк үндэстэн, орчоон үндэстэн байна. Энэ дөрвөн үндэстний хэлний өнөөгийн байдал, хүн амын тоо, нутгийн аялгуунуудын талаар тус өгүүлэлд тоймлон өгүүлнэ.

2. Судалгааны арга зүй

Миний бие (Цэрэнбат) БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөлөнбуйр хотын иргэн, эвенк үндэстэн хүн бөгөөд Хөлөнбуйр дээд сургуульд олон жил багшилж байна. Иймээс эвенк үндэстнийхээ хувьд эвенк хэлтэй, өвөр монголчууд, жич дагуурчуудын дунд ажиллаж амьдардгийнхаа хувьд монгол, дагуур хэлтэй, Хятад улсын иргэнийхээ хувьд хятад хэлтэй, хэл шинжлэлийн судлаач, багш хүнийхээ хувьд тус дөрвөн хэлийг тодорхой хэмжээнд сонирхон судалдаг билээ. Тиймээс амьдран буй орчин, нутаг усныхаа хүн амын хэлний тойм байдлыг ажиглан мэдэх буюу жирийн ажиглалтын арга, тухайн хэлтэн хүмүүстэй уулзан ярилцах буюу асуулт байцаалтын аргаар тус өгүүлэл дэх мэдээллийг цуглууллаа.

3. Монгол төрөл хэл, түүний аялгуунуудын тухай

Ч.Зээнямбуу, М.Базаррагчаа нар “Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь”-доо “Төрөл хэл (Cognate /related/ language) нь нэг үндсэн (өвөг) хэлнээс үүссэн хэл. Нэг үндсэн гаралтай боловч түүхэн элдэв үед салж тасран, тус тусдаа өөр өөрийн хөгжлөөр хөгжсөн хэлнүүд юм. Төрөл хэлийг дотор нь хол, ойрын төрөл хэл гэж ялгадаг. Жишээ нь: монгол хэл гэхэд (халх монгол, өвөр монгол), дагуур, буриад, ойрад-халимаг, монгол, могол, бао-ань дуншаан хэл нь ойрын төрөл хэлнүүд юм. Харин монгол, түрэг, манж, солонгос, япон хэл нь холын төрөл хэлнүүд болно” (Зээнямбуу нар, 2014: 348) гэж тайлбарлажээ.

Монгол, дагуур, дуншаан, бао-ань, зүүн ёгур, жич могол, канжя хэлнүүд төв монгол хэлнээсээ нэгэнт алслан холдож, өдгөө биеэ даасан хэл болон хөгжсөнийг эрдэмтэн судлаачид үндсэндээ хүлээн зөвшөөрч иржээ. Харин ойрад, буриад, мөн өвөр монголчуудын хэлэлцэж буй хэл яриа нь хэл үү, аялгуу юу гэдэг тухайд харилцан адилгүй саналтай байдаг.

ОХУ дахь Буриад Улс, Халимаг Улс болон бусад мужид тархан суурьшсан хүн амын хэлэлцдэг хэл яриа нь орос хэлний нөлөөг үлэмж хүртэж, холимог хэлний шинжтэй бие даасан буриад болон халимаг хэл болжээ. БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны болон Шинжаан-Уйгурын Өөртөө Засах Орны хүн ам нь өөрсдөө монгол хэлтэн гэсэн үзэл бодолтой, баримжаа авиа – цахар аман аялгуу нь халх аялгуутай харьцангуй ойр дөт байдаг. Гэвч тэд Буриад Улс, Халимаг Улсын нэгэн адил өөрийн орны хил хязгаартай, худам монгол үсэгт суурилсан бичгийн хэлтэй, тэр нь өөрийн гэсэн зөв бичих, дуудах, найруулах хэм хэмжээтэй, суурь аялгуутай, дотроо бас нутгийн аялгуунууд, түүн дотроо аман ба салбар аман аялгуунуудтай юм. Хэлэлцэгч хүн амын тоог авч үзвэл цахар аман аялгуутан эдүгээ 460000 орчим бөгөөд энэ нь өвөр монголчуудын 10,78% бол хорчин аман аялгуутан 2080000 орчим бөгөөд дангаараа 48,77%-ийг эзэлж байна (Үлдсэн 40,45% нь ордос, алшаа, баарин, харчин, барга-буриад зэрэг аялгуутнууд)¹. Хорчин аман аялгуу нь үгийн сангаас гадна хэл зүй, авиа зүйн түвшинд хятад хэлний нөлөөг үлэмж хэмжээгээр хүртэж, өдөр тутмын аман яриаг нь Монгол Улсын хүн ойлгоход улам бүр төвөгтэй болж байна. Ийнхүү тэд хоёр хэлтнээс холимог хэлтний шинж рүү аажмаар шилжиж, буриад хэл, халимаг хэлний нэгэн адил бие даасан хэл болон хөгжиж байгааг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүйд хүрч байгаа юм. Харин нэр томьёоны хувьд академич Д.Төмөртоогоо Монгол Улсаас өмнөд зүгт байрлах газар нутгийн байршлаар нь “Өмнөд монгол хэл” гэж нэрлээд, 10 монгол хэл бий гэсэн (Төмөртоогоо, 2023: 70)-тэй бид санал нэг байна. Жич: ШУӨЗО-ы болон Хөхнуур, Ганьсу муж зэрэг газар тархан суурьшсан ойрад монголчуудын дотор угсаатны ухамсрын үүднээс тод үсгээ мэддэг, хэрэглэдэг хүмүүс цөөнгүй байдаг боловч албан ёсоор худам монгол бичиг үсгээ хэрэглэдэг. Харин Хөхнуур мужийн Хуаннаны төвөд үндэстний өөртөө засах жеу Жяньжа шяны Кан-ян балгасанд нутгийн хэлээр ярилцдаг нэг бүлэг хотончууд байдаг. Тэдний хэл яриаг өнгөрсөнд бао-ань хэлний нэг нутгийн аялгуу гэж үзэцгээдэг байсан. Сүүлийн жилүүдэд эдгээр хотончуудын хэл яриаг монгол төрлийн бие даасан бас нэг хэл – канжя хэл гэж үзэх болж байна.

Ийнхүү, өнөөдөр “Монгол хэлнүүд” хэмээх ойлголтод монгол, өмнөд монгол, буриад, халимаг, дагуур, дуншаан, бао-ань, монгор, зүүн ёгур, канжя², могол³ гэсэн 10 төрөл хэл багтаж байна. Гэхдээ өдгөө амьд хэрэглэгдэж буй нь 8 байна. Эдгээр нь тус бүр дотроо нутгийн болон аман аялгуунуудтай, зарим нь салбар аман аялгуунуудтай.

Үүнээс Хөлөнбуйр хотод өмнөд монгол хэлний зарим аялгуутан, мөн дагуур хэлтэн хүмүүс байна.

3.1. Өмнөд монгол хэл, түүний аялгуунууд

Өвөр монгол, ар монголчууд эрт үеэс хамт аж төрж, монгол угсаатны гол цөм болсоор ирсэн бөгөөд XIV зуун гэхэд Монголын зургаан түмэн нь Халх, Цахар, Ордос зэрэг тус тусын нэртэй байв. Гэвч 1600-аад оны эхэн үеэс Манж Чин улс Монголын өмнөд хэсгийг бага багаар эзлэн авсаар, 1636 онд Өвөр Монголыг бүхэлд нь эзэлсэн байна. Тэр үеэс өвөр монголчууд тусгаар амьдрах түүх эхэлж, 1911 оны хувьсгалаас хойш Бүгд Найрамдах Хятад Ард Улсын албан ёсны нэг хэсэг болжээ. 1947 онд Өвөр Монголын Өөртөө Засах Орныг тунхагласан байна. Өдгөө нийслэл нь Хөх хот, 2020 оны байдлаар 24,049,155 (23-р олон) хүн амтай, хүн

¹ https://mn.wikipedia.org/wiki/Өвөр_Монголын_Өөртөө_Засах_Орон

² Дээр зууны ерээд онд хийсэн байцаалтаар канжягийн хотончууд нийт 2000 гаруй хүн байх бөгөөд 480 гаруй нь канжя хэлээ мэддэг байсан гэнэ. Гэтэл Тайваний эрдэмтэн Сяо Сү Ин-ий сүүлийн үед хийсэн байцаалтаар одоо канжя хэлээр ярилцдаг хүн 180 орчимхон үлдээд буй. (Сэцэнбаатар, 2005: 91-92).

³ Германы эрдэмтэн М.Weiers-ийн мэдээлснээр Афганистан дахь моголчууд 3000 орчим буй. Тэд бүгд исламын шаахин шүтдэг бөгөөд орчин үе болтол малжих амьдралын зан дадгалаа хадгалсаар байв... 1970 онд Монгол улсад болсон олон улсын монголч эрдэмтдийн хоёрдугаар их хурал дээр S.Нотат гэгч могол хүн “Афганистаны могол хүн” гэдэг сэдвээр илтгэл тавьсан бөгөөд Херат муж дахь моголчуудын төвлөрөн суудаг Күнтүр, До рүди зэрэг хэдэн тосгоны настайчуул могол хэлээрээ харилцдаг гэж мэдээлсэн билээ. Холбогдол бүхий мэдээ сэлтээс үзэхэд моголчуудын дотор могол хэлээ мэддэг хүн одоо бараг байхгүй болсон төлөвтэй бөгөөд тэдний зарим нь перс хэлтэн, зарим нь пүшү хэлтэн ба тажик хэлтэн болсон байна” (Сэцэнбаатар, 2005: 96-97).

амын 78.8%-ийг хятад үндэстэн, 17.7%-ийг монгол үндэстэн, 3.6%-ийг бусад үндэстэн эзэлж байв (https://mn.wikipedia.org/wiki/Өвөр_Монголын_Өөртөө_Засах_Орон). Хятад дахь монгол үндэстэн ӨМӨЗО-д төвлөрөхөөс гадна Шинжаан-Уйгурын Өөртөө Засах Орон, Хармөрөн, Гирин, Ляонин, Ганьсу, Хөхнуур, Хэбэй мужид олноор аж төрдөг. Мөн Бээжин хотод болон бусад газар нутгаар тархан суусан монголчууд ч буй. Хөдөө орон нутгийн монголчууд хагас мал аж ахуй, хагас газар тариалан эрхэлж, хот суурин газрынх нь орчин үеийн аж амьдралаар суурьшин амьдардаг. БНХАУ-д суугаа монгол үндэстэн тоогоор дэлхийн монголчууд дотор хамгийн олон бөгөөд 2000 оны бүх улсын хүн амын тооллогоор зургаан сая гаруй байна. Гэвч тэдний дотор хоёр хэлтэн буюу хятад хэлнээс гадна монгол хэлээ мэддэг хүн түүнээс цөөн байдаг. Тэд монгол хэлнийхээ худам монгол бичгийг нийтээр хэрэглэдэг.

Хятад улс дахь монгол хэл нь дотроо төв буюу өвөр аялгуу, баруун буюу ойрад аялгуу, зүүн буюу барга-буриад аялгуу хэмээх гурван нутгийн аялгуутай. Үүнээс өвөр монгол аялгуу нь цахар, ордос, алшаа-эзнээ, баарин, хорчин, харчин-түмэд гэсэн зургаан аман аялгуутай, тэдгээр нь дотроо бас салбар аман аялгуунуудтай. Барга-буриад аялгуу нь буриад аман аялгуу, барга аман аялгуутай, барга нь хуучин барга, шинэ барга салбар аман аялгуутай. Ойрад аялгуу нь дөрвөд, торгууд аман аялгуутай.

Эдгээрээс Хөлөнбуйр хотод хуучин барга, шинэ барга, буриад мөн өөлд аялгуутан хүмүүс байна.

2018 онд хэвлэгдсэн “Өвөр Монголын монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн байцаалтын материалын цуврал”-аар Сэнгэ, Наранчимэг нар “Хөлөнбуйр аймаг (Хөлөнбуйр хот)-ийн ботийг хэвлүүлжээ. Түүнд өмнөд монгол хэлний барга-буриад болон өөлд аялгууны материал орсон байна. Уг ном нь ‘Хөлөнбуйрын монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн байцаалтын материал’, ‘Хөлөнбуйрын монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн сонгомол’ хэмээх хоёр хэсгээс бүтэх бөгөөд эхний хэсэгт дан үг, хэл зүй, биеийн төлөөний нэр ба заах төлөөний нэрийн байцаалтын материалыг багтаажээ. Дан үгийн хэсэгт 2000 онд Хөлөнбуйрын барга-буриад угсаатан амьдардаг 31 суманд очиж тэмдэглэж авсан 250 дан үгийг монгол-хятад хэлээр тольчлоод, тухайн сум бүрд хэрхэн хэлдгийг галигаар тэмдэглэжээ. Хэл зүйн хэсэгт нэр, үйлийн хувилал, төлөөний нэрийн талаар 100 асуулт гаргаж, 2000 ба 2016 онд байцаан тэмдэглэснээ мөн 31 суманд хэрхэн хэлдэг байдлыг галиглан үзүүлж, тусгайлан биеийн ба заах төлөөний нэрийн тийн ялгалын хувирлыг хошуу хошуугаар буюу салбар аман аялгуугаар хүснэгтлэн үзүүлсэн байна. Газрын зургийн сонгомолд нэлээд онцлогтой гэж үзсэн 69 үг, хэл зүйн 4 хэлбэрийг 31 сумын нутаг дэвсгэр дээр дугаарлан тэмдэглэж үзүүлсэн байна. Энэ нь 1979 онд академич Б.Ринчений удирдлага дор Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэд “Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас” бүтээж, Монгол улсын нутаг дахь аялгууны тархац, тэдгээрийн авианы онцлогийг тодорхой үгсээр төлөөлөн газрын зурагт нарийн тодорхой тэмдэглэн үзүүлсэнтэй арга зүйн хувьд төстэй юм.

3.1.1. Барга-буриад аялгуу

Барга-буриад аялгуутан дотроо шинэ баргачууд нь хүн амаар хамгийн олон бөгөөд дөрвөн түм дөрвөн мянга (44000) гаруй. Тэд Хөлөнбуйр хотын Шинэ барга баруун хошуу, Шинэ барга зүүн хошуу хэмээх хоёр хошуунд төвлөрөн амьдардаг.

Хуучин баргачууд нь хоёр түм хоёр мянга (22000) гаруй хүн амтай. Хуучин барга хошуунд төвлөрөн амьдардаг. Хуучин барга аялгуунд манж-түнгүүс төрөл хэлний үгс олноор орж, эвенк хэлний нөлөөг илүү их хүртсэн.

Буриад нь Эвенк хошууны Шинэхээн баруун, Шинэхээн зүүн, Мөнгөнчулуу сумдад төвлөрөн суурьшсан шинэхээн буриадууд юм. 8000 гаруй хүн амтай.

Барга ба буриад нь уг гарваль нэгтэй тул хэл яриа нь ерөнхийдөө нийтлэг шинжтэй. Тухайлбал, бусад монгол хэл, аялгууны [s] гийгүүлэгчийг төвөнхийн [h]-ээр, хамжин шүргэх чанга [ʃʰ], [tʰ] гийгүүлэгчийг шүргэх [ʃ], [s]-ээр, хамжин шүргэх сул [ʃ̥], [t̥] гийгүүлэгчийг сул шүргэх [ʒ], [z]-ээр хэлэх зэрэг гол шинж нь байна. Жишээ нь: [hana:] – *санаа*, [naha] – *нас*, [sak]

– *сэг*, [ɔnsɔlik] – *онцлог*, [aliʃ] – *аль ч*, [aza] – *аз* гэх мэт. Гэвч зарим газар бас алдагдаж, сахар аялгууных шиг *s>[s]*, *ᠰ>[ʃʰ]* гийгүүлэгчээр хэлдэг болж байна. Жишээ нь: [aras] – *арьс*, [sar] – *сар*, [xowʃis] – *хувцас*, [æ:mɔs] – *оймс*, [mɔŋɔɔltʃʰo:d] – *монголчууд*, [ʃawʃ] – *шавж* гэх мэт. Мөн *эсгий* – буриад.[həʃi:], барга.[iʃyi:]; *анжис* – буриад.[anzahaŋ], барга.[anʃho:]; *шээзгий* – буриад.[hə:zyi:], барга.[sə:tsyi:~хэ:tsyi:]; *оймс* – буриад.[ɔimhəŋ], барга.[æ:mho:]; *ус* – буриад.[ohon], барга.[oho]; *нулимс* – буриад.[nɔlbɔhon], барга.[nolimho:n~nolimos]; *ноднин* – буриад.[nɔdɔndɔ], барга.[nɔdɔnəŋ~nɔdɔŋ]; *надаас* – буриад.[namha:], барга.[nada:s]; *надтай* – буриад.[namtʰe:], барга.[nadtʰi:]; *чамаас* – буриад.[ʃamha:], барга.[ʃama:s~ʃʰama:s]; *чамтай* – буриад.[ʃamtʰe:], барга.[ʃamtʰi:~ʃʰamtʰi:] гэх мэтээр өөр өөрийн онцлогоо хадгалж байна (Сэнгэ нар, 2018).

Анх 1936 онд Ш.Хаттори “Хөлөнбуйрын алтай хэлт үндэстэн” хэмээх бүтээл Хөх хотод хэвлүүлж байсан бол Өвөр Монголын Их Сургуулийн Монгол хэл бичиг судлах газраас 1980 онд шинжилгээний анги зохион байгуулжээ. Түүний үр дүнд эрдэмтэн Ууда нар “Барга аман аялгууны үг хэллэгийн материал” /Монгол төрөл хэл аялгууны судлалын цуврал - 002/ (1984), “Барга аман аялгууны үгс” /Монгол төрөл хэл аялгууны судлалын цуврал - 003/ (1985) хэмээх бүтээлүүдээ хэвлүүлсэн байна. Дараа нь Боошиан, Жараннэг нарын “Барга аман аялгуу” (1996) зэрэг бүтээл хэвлэгдсэнээр ӨМӨЗО-ы Хөлөнбуйрын барга аман аялгууг харьцангуй бүрэн хэмжээгээр судлан гаргасан байна. Түүнээс хойш барга-буриад аялгууны талаар Шинэтгэ (1987), Диян Шиюү (1998), Г.Цэрэнханд, О.Баттуяа нар (2005), Саруул (2008), Зандан (2008), Номин (2016), Бадамцоо (2018), Урьхан, Туяа нар (2019), Содон (2020) нарын бичсэн өгүүлэл нийтлэгджээ. Барга аман аялгууны талаар Пүрэв (1985, 1987, 1988), Боошиан (1990), Эрдэнэцугла (1998), Хей Хуа (1999), Бүрэнбилиг (2013), Шиюү Хуан (2015), Сүеэ (2016), Сэцэн, Хувьт нар (2016), Күн Сүн Ян (2016, 2017), Е.В.Сундеева (2019), Мэй Хуа (2019) нарын өгүүлэлүүд гарсан байна. Шинэхээн буриад аман аялгууны талаар Д.Б.Базарова (2008), Ц.Норжин (2013), Сарангэрэл (2017), Толон (2022) зэрэг судлаачдын бүтээл гарчээ. (Батзаяа нар, 2024: 99-114). Ийнхүү Хөлөнбуйрт буй барга-буриад аялгууг нэлээд сайн судалсан байна.

3.1.2. Өөлд аялгуу

Хөлөнбуйрт Барга-буриадаас гадна өөлдүүд бий. Тэд Хөлөнбуйр хотын Эвенк үндэсний өөртөө засах хошууны Имин суманд суудаг, хүн ам нь цөөн, 700 хүрэхгүй. Имин голын урсгал дагуу амьдарч байгаа болохоор Иминий өөлдүүд ч гэдэг. Тэдний хэл ярианы тухай одоо болтол судалгаа тун ховор. Өнөөг хүртэл өмнөд монгол хэлний нутгийн аялгууны хуваарилалтад ч тодорхой тусгасан зүйл байхгүй.

Хэл аялгууны шинжийн хувьд уулаасаа ойрад аялгуунд багтах боловч монгол нутгаасаа гараад Хөлөнбуйр нутгийн барга-буриад болон эвенк хэлтэнтэй нэгэн нутагт гурван зуу гаруй жил холилдон амьдарсан тул тэдний хэл аялгууны нөлөөнд орж, уусан нийлэх хандлагатай болжээ. Хэдий тийм боловч уугуул аялгууных нь онцлог шинж бага зэрэг хадгалагдан үлджээ. Тухайлбал: өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн нь өгүүлбэрийнхээ эцэст хураагдан орох, эсвэл бие заасан нөхцөл хэлбэрээр хэлэгддэг байна. Мөн барга-буриад аялгууны авианы сулрал байхгүй. Жишээ нь: [ɔnɔ: iɣwʊ:ʃʰ] – *өнөө ирэв үү чи?* [ɔʃʰwo:tʰ] – *очив уу та?* гэх мэт.

Түүнчлэн үгийн дуудлага болон үгийн сангийн талаар цөөн боловч ялгаа байгааг 2018 онд гарсан “Хөлөнбуйр аймаг (Хөлөнбуйр хот)-ийн боть”-д тэмдэглэсэн үгсийн жишээнээс авч жагсаавал:

Барга-буриад. [aʃʰa:~aʃa:] – *ачаа*, өөлд. [tʰeŋne:] – *тэгнээ*
 Барга-буриад. [aɣʰai~aɣʰæ:], өөлд. [aɣwa:] – *арвай*
 Барга-буриад. [uβyən], өөлд. [əwʊyən] – *өвгөн*
 Барга-буриад. [hələm], өөлд. [sələm] – *сэлэм*
 Барга-буриад. [oilax~wæ:laχ], өөлд. [o:liχ] – *уйлах*
 Барга-буриад. [oho~ohon], өөлд. [os] – *ус*
 Барга-буриад. [uyle:], өөлд. [øylø:] – *өглөө*
 Барга-буриад. [biʃiq], өөлд. [biʃʰik] – *бичиг*
 Барга-буриад. [nu:ɣhu:~nu:ɣhə], өөлд. [nu:rs] – *нүүрс*
 Барга. [ajo:lχi:], өөлд. [æwilχæ:] – *авилхай*

Буриад. [həji:], өөлд. [iʃxɛ:] – эсгий

Ийнхүү тэд цөөхүүлээ, монгол нутгаасаа, ойрад угсаатнаасаа алс хол, барга-буриад болон эвенкчүүдийн дунд олон жил амьдрахдаа өөрийн аялгууны онцлогоо өнөө хүртэл ямар нэг хэмжээгээр хадгалсаар байна. Тэдний хэл яриаг шинжилж, гол цөмөөсөө алслагдсан аялгуунд үлдэж хоцорсон шинжийг судалж үзвэл ойрад аялгууны хамгийн чухал ‘амь бөхтэй’ онцлогийг илрүүлж болох сонирхолтой судалгаа болох юм.

3.2. Дагуур хэл, түүний аялгуунууд

Дагуур бол БНХАУ-ын 56 үндэстний нэг юм. Хөлөнбуйрын дагуурчуудыг өнгөрсөн үед дагуур монгол гэх буюу монгол үндэстний дотор баргад багтаан үздэг байсан нь гагцхүү газар нутгийн байршлаар нь хамтатган үзэж байсан хэрэг юм. Угтаа дагуурчууд нь бие даасан үндэстэн бөгөөд өөрсдийгөө Хятаны хойчис гэж үздэг. Дагуур хэл бол алтай язгуур хэлний монгол төрөл хэлэнд багтдаг, монгол хэлний харьцангуй эрт үеийн онцлог шинжийг нэлээд сайн хадгалж буй хэл юм. Өдгөө бараг 13 түмэн (130000) дагуур үндэстэн хүн ам байх боловч цөөнх нь өөрийн хэлээр болон хятад хэлээр ярьдаг хоёр хэлтэн, олонх нь хятад хэлтэн болж байна.

Дагуурчуудын дээд өвөг Амар мөрний дунд хэсгээр оршин сууж байгаад, XVII зууны үед Хятадын нутагт нүүдэллэн орж, улмаар хэдэн хэсэг салж, бие биеэсээ хол тархан суурьшжээ. Өдгөө цөөнх нь Амар мөрөндөө үлдэж, ихэнх нь ӨМӨЗО-ы Хөлөнбуйр хот, Хармөрөн мужийн зарим шян, Чичихаар хот, ШУӨЗО-ы Тарвагатай шянд нутагладаг (Хас-Эрдэнэ, 2014: 1-2). Дагуур хэл нь дотроо чичхаар, будха, хайлаар, шинжааны тарвагатай хэмээх дөрвөн нутгийн аялгуутай. Аялгуунуудын хоорондох зөрөө нь тийм ч их биш. Будха дагуурчууд нь тоогоор хамгийн олон бөгөөд голлох аялгуу.

Эндээс Хөлөнбуйрт будха, хайлаар хоёр аялгуутан нь байх бөгөөд Морин даваагийн дагуур үндэсний өөртөө засах хошуу, Эвенк үндэсний өөртөө засах хошууны Баянтал сум, Баянтохой балгас, мөн Хайлаар хотод цөөн хүн ам суудаг.

Дагуур хэлний судалгааг анх А.О.Ивановский хийж, 1894 онд “Образцы солонского и дахурского языков” хэмээх өгүүллээ нийтлүүлсэн бол 1906-1908 онд Шинжааны дагуур аялгууг судалсан Ф.В.Муромскийн хэвлэгдээгүй бүтээлийг хожим Польшийн эрдэмтэн С.Гожинский (1970), С.Калужинский нар (1969, 1970) хэвлүүлсэн байна. Өнгөрсөн зууны гучаад онд Н.Поппе “Дагурское наречие” хэмээх ном (1930) болон “Дагуур хэлний тухай” (1935) гэсэн өгүүлэл бичсэн бүтээлээ хэвлүүлжээ. 1986 онд Б.Х.Тодаева “Дагурский язык” бүтээлээ хэвлүүлж, В.М.Аустин “Дагуур хэлний тухай товч тойм” (1952), С.Мартин “Дагуур хэлний Будха аялгууны авиа зүйн тухай тэмдэглэл” (1983) хэмээх томоохон өгүүлэл нийтлүүлсэн нь дагуур хэлний авиа зүйн талаар гарсан дэлгэрэнгүй судалгаа болсон байна.

1980-аад оны үеэс Өвөр Монголын эрдэмтэд БНХАУ-ын нутаг дэвсгэр дээрх монгол хэл аялгуунуудын хэлний судалгааг эхлүүлсний дотор дагуур хэлний талаар нилээд олон бүтээл нийтлэгджээ. Тухайлбал: Намсрай, Хас-Эрдэнэ нарын “Дагуур ба монгол хэлний харьцуулал” (1983), Энхбат нарын “Дагуур хэлний үгс” {Монгол төрөл хэл аялгууны судлалын цуврал 005} (1984), “Дагуур хэлний үг хэллэгийн материал” {Монгол төрөл хэл аялгууны судлалын цуврал 006} (1985), “Дагуур хэл ба монгол хэл” {Монгол төрөл хэл аялгууны судлалын цуврал 014} (1988) зэрэг бие даасан цуврал бүтээл гарснаас гадна Бадрангаагийн “Дагуур хэлний зарим гийгүүлэгчийн учир” (1989), Д.Түмэндэмбэрэлийн “Дагуур хэлний эгшиг, гийгүүлэгч авианы үндсэн онцлог шинжүүд” (2000), Ехэ Ямадагийн “Дагуур хэлний цагийн ай” (2017) гэх мэт өгүүллүүд гарсан нь дагуур хэлний судалгааны хүрээг ихээхэн тэлжээ.

Саявтархан (2014) уугуул дагуур үндэстэн Г.Тумурдэйн хэл аялгууны материал дээр тулгуурлан ОХУ-ын буриад судлаач Б.Д.Цыбенев “Дагуур-орос товч толь бичиг” эмхэтгэн хэвлүүлсэн нь дагуур хэлний үгийн сангийн судлалыг баяжуулсан бүтээл болжээ.

Эвенкийн дагуурчууд нь Морин даваагийн дагуурчуудаас харьцангуй илүү монголжуу шинжтэй бөгөөд эртний болон дундад эртний монгол хэлний онцлогийг нэлээд хэмжээгээр хадгалдаг. Тухайлбал, дагуур хэлэнд харьяалах, заах тийн ялгалын нөхцөл нь [-i/-ji:] байдаг. Жишээ нь:

[bi: aili: əməl bəjd nək kərd a:ʃaw] – Би айлын өмнө биед нэг гэрт байж байв.

[teɾ kersu:li: ɣo: ən ɣarbən ɣo:nd bailka:sən] – Тэр гэрсүүлийг хуу энэ арван онд байлгасан (Тэр барилгуудыг бүгдийг сүүлийн арван жилд барьсан).

Дээр дурдсан хоёр тийн ялгалын адил бүтэцтэй нөхцлийг зөвхөн өгүүлбэрийнх нь утгаар ялгана. Жишээ нь:

[mɔri: hu:l] – морины сүүл,

[mɔri: ən] – морийг уна.

Хэрэв тухайн өгүүлбэрт биеийн төлөөний үг байвал түүгээр баримжаалан ялгаж болно.

[mini: makalmin] – миний малгай (минь)

[nami: daudiʃa:bei] – намайг дуудаж байна.

Дагуур хэлэнд манж-түнгүс төрөл хэлний нөлөө ихээхэн нэвтэрсний нэг илрэл нь [o], [u] эгшиг бараг хэлэгдэхгүй болж, олонх тохиолдолд [ɔ], [ɵ] эгшгээр дууддаг. Жишээ нь: [ɔs] – ус, [ɔŋ] – унш гэх мэт.

Дагуурчууд өөрийн үндэстний гэсэн бичиг үсэггүй, Чин улсын үед манж бичиг хэрэглэж байгаад, 1930 оноос латин, 1950 оноос кирилл үсэг авч хэрэглэж байсан бол 1980 оноос хойш хятад ханз үсэг хэрэглэх болсон байна. Дагуур хэлэнд өвөг монгол хэлний анхдагч урт эгшиг, эртний монгол хэлний үүсмэл урт эгшиг, дунд үеийн монгол хэлний эгшгийн ижилшил, үгийн эцсийн бус үеийн хос эгшиг, үгийн эхний шүргэх гийгүүлэгч зэрэг шинж хадгалагдан үлдсэнээс гадна бусад монгол хэлнүүдийн адил урт, хос эгшиг, эгшгийн ижилшил зэргийг зохих хэмжээгээр тусгасан байдаг (Төмөртоого, 2017: 73-78). Мөн харьяалах, заах тийн ялгал адил нөхцөлтэй (Батзаяа, 2020: 43-56), бие заах нөхцөл болон өгүүлэгдэхүүн өгүүлэхүүн хоёр нь бие заах нөхцөлөөр зохицдог зэргээрээ төв монгол хэлнээс бусад монгол төрөл хэлнүүдтэй адил (Батзаяа, 2022: 207-2011) шинжтэй. Дагуур хэл нь гуравдугаар биеийн төлөөний үгийн эртний -in (ганц тоот), -an (олон тоот) үндсийг авч үлдсэн орчин цагийн ганц монгол хэл юм (Хас-Эрдэнэ, 2014: 196-199).

4. Манж-түнгүс төрөл хэл, тэдгээрийн аялгуунуудын тухай

Хөлөнбуйр хотод манж-түнгүс төрөл хэлний эвенк болон орчоон хэлтэн оршин суудаг. Тэд Эвенк үндэсний өөртөө засах хошуу болон Орчоон үндэстний өөртөө засах хошуунд төвлөрөн аж төрж байна.

4.1. Эвенк хэл, түүний аялгуунууд

Хөлөнбуйр хотын Эвенк үндэсний өөртөө засах хошууны Хой, Имин, Баянцагаан сумд, Баянтохой балгас, Гэгээнгол хотын Олгуйяа эвенк суманд суугаа эвенк үндэстэн өдгөө 30000 гаруй хүн амтай боловч хагас нь л уугуул хэлээ мэддэг. Эвенк хэл бол алтай язгуурын хэлний манж-түнгүс төрөл хэлний түнгүс салбарын хэлэнд багтдаг тул монгол хэлтэй нэг язгуурын, манж хэлтэй нэг төрлийн хэл юм.

Эвенк хэлний гурван аялгуу нь өөр хоорондоо авиа зүйн хувьд голчлон ялгардаг. Тухайлбал, солоон аялгуунд эгшиг зохицох ёс хатуу тогтолцоотой бол нөгөө хоёр аялгуунд сул байдаг. Солоон аялгуунд гийгүүлэгч ижилсэх хувьсал нийтлэг байдаг учраас давхар гийгүүлэгч олон тохиолддог. Солоон ба якут аялгуунд [ɵ], [u], [ɵ:], [u:] эгшгүүд байдаг бол түнгүс аялгуунд байдаггүй. Якут болон түнгүс аялгуунд нийлмэл эгшиг нийтлэг шинжтэй байдаг бол

солоон аялгуунд тийм нийлмэл эгшиг байдаггүй. Солоон аялгуу нь бусад аялгуунаасаа илүү олон гийгүүлэгчтэй. Түнгүүс болон якут аялгуунд үгийн эхэнд [h] гийгүүлэгч уламжилж үлдсэн байдаг бол солоон аялгуунд байдаггүй. Жишээ нь: *өвдөг* – түнгүүс, якут [heŋkeŋ], солоон.[eŋkeŋ] гэдэг. Дурдсан гурван аялгуу нь богино болон урт эгшигтэй бөгөөд тэдгээр нь утга ялгах авиалбарын үүрэгтэй.

Хэл зүйн хувьд, нэр үг нь олон тоо, тийн ялгал, хамаатуулах айтай, тэдгээр нь өөр өөрийн нөхцөл бүтээвэртэй. Үйл үг нь хэв, байдал, цаг, биеийн айтай, бүгд өөр өөрийн нөхцөлтэй. Жишээ нь: [ulme] – *би явна*, [uldu] – *би явжээ*, [ulyere:] – *би явъя*, [ulk^{he}] – *чи яв* гэх мэт.

Үгийн сангийн хувьд монгол хэлтэй адил үг цөөнгүй байх бөгөөд тэдгээрийг харьцангуй эртний хэлбэрээр нь хадгалж үлдсэн байдаг. Жишээ нь: [mɔŋiŋ] – *морь*, [χɔŋiŋ] – *хонь*, [tɔmɔ:ŋ] – *тэмээ*, [ima:ŋ] – *ямаа*, [tsɛ:rɛŋ] – *зээр*, [miŋqan] – *мянга*, [altʰaŋ] – *алт*, [mɔyɔŋ] – *мөнгө*, [tʰɔryɔŋ] – *тэрэг* гэх мэтээр нэр үгсийг эцсийн гийгүүлэгчтэйгээр нь хадгалж үлдсэн. Дээрх гурван аялгуунд ялгаатай үгс цөөнгүй бий. Жишээ нь: уул – солоон.[ur], якут.[ure], түнгүүс.[ɔrɛŋ] гэх мэт.

Эвенкчүүд үеийн үед хадгалж ирсэн уугуул хэлтэй боловч өөрийн үсэг бичиггүй. Чин гүрний үед манж бичиг хэрэглэж байгаад хожмоо мал аж ахуй эрхэлдэг эвенкчүүд монгол бичиг, газар тариалан, ан агнуур эрхэлдэг эвенкчүүд нь хятад үсэг бичиг сурч хэрэглэж байсан бөгөөд одоо бараг бүгдээр хятад үсэг бичиг сурах хандлагатай болжээ.

Эвенк хэлний талаар Өвөр Монголын эрдэмтэн Цэрэнбат, Цог нар судалгааны олон бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл, сургалтын материал хэвлүүлсэн байна. Цэрэнбат 2007 онд “Эвенк хэл ба монгол хэлний харьцуулсан судалгаа” сэдвээр эрдмийн зэрэг хамгаалжээ.

Хамниган эвенкчүүдийн талаар Өвөр Монголын эрдэмтэн Ж.Сэндмаа судалж 2011 онд “Хамниган эвенк судлал” хэмээх нэг сэдэвт бүтээл хэвлүүлсэн байна. Тэрээр “*Алтай язгуурын хэлний нэг болох манж түнгүс төрлийн эвенк хэлтэн буюу эвенкчүүд нь МЭ I зуунд өмнө талаараа Хятан улстай хил залган оришиж байсан Дундад улсын зүүн хойд орны Шивэй хэмээх анчин ахуйтай нэгэн угсаатнаас гаралтай. Шивэйчүүдийн зарим нь дагуур, манж, монгол угсаатанд уусан нэгдэж, голдуу хос хэлтэн болсон бөгөөд харин бусдад уусалгүй эх хэлээ хадгалан үлдсэн нь орчоон ба эвенк үндэстнүүд юм... Эвенкчүүд бол ангийн нүүдлээр явдаг, тогтмол орон сууцгүй анчин үндэстэн юм. Тэд гүн уул, балар ойгоор араатан амьтан агнаж, аж төрдөг байсан тул жилийн дөрвөн улиралд зохицуулан, ан гөрөөг мөрдөн дагаж нутаг шилждэг байв. Цаа буга бол хөвд иддэг амьтан тул хөвд ургамлын судсыг даган, уул хайрхан, ой хөвчөөр шинэ соргог хөвд эрэн идишилдэг юм. Цаа бугын эзэн бологч бугачин эвенкчүүд мөн цаа бугынхаа хойноос даган нааш цааш нүүдэллэн явдаг байжээ. Тиймээс анчин, бугачин эвенкчүүд нь Байгал далайн зүүнтээх ойт уул, Гадаад Хянган даваа, Хармөрөн, Жинхирмөрөн, Ниуман голын сав газраар нүүдэллэн шилжиж, хаа хүрсэн газартаа үйсэн гэрээ барьж, ангийн мах, сүүгээр идээ умдаагаа болгосон чөлөөт амьдралыг хийж байв*” (Сэндмаа, 2011: 25-26) гэх мэтээр бичжээ.

Харин Монгол Улсад нүүдэллэн ирж суурьшсан хамниганчуудын тухай академич Б.Ринчен “*Ер, хамниган ястныг нийт дор авч өгүүлбээс, монгол, түрэг лүгэ зэрэгцэн нангиад /хятад/ сударт дөрвөн мянган жилээс нааш оролцож ирсэн хуучны их үндэстэн даруй мөн болох бөгөөд дорно дахь гадаад далайн эргээс өрнө дэх их Алтай хүртэл ба монгол говиос умард мөсөн далай хүртэл тархаж түгсэн нь цаг үес ба газар оронд алдар адилгүй боловч бие бялдрын шинж ба хэлний шинж нь нэгэн үндэстний ард хэмээн мэдэгдмээр баймой. /Солоон, манж хэл, хамниган хэл нэгэн төрөл буюу/”* (Ринчен, 1969: 8) хэмээсэн байдаг. Тэрбээр аялгууны хувьд: Б.Ринчен “*Өдгөө бүхүй хамниган, монголын дунд цөөн тооны хүмүүс суух тул эх хэлээ мартаж, монгол халхын хэлтэй болсон ба... ахмад насны хамниганы нэгэн хэсэг нь орчин хавийн монголчуудаас баахан өөр татлагатай аман аялгуугаар хэлэлцдэг... тэр нь хамнигацуулын аманд үлдсэн монгол аман аялгууны зүйл байнам*” (Ринчен, 1969: 12, 81) хэмээн дүгнэжээ. Түүнээс хойш Монгол Улсад буй хамниганы тухай судалгаа цөөн хийгдсэн бөгөөд 2006 онд Андрей Шимүнекийн “Монгол дахь мөхөж буй хамниган монгол хэлийг саяхан сурвалжилсан бяцхан тэмдэглэл”, 2019 онд Эрдэнэтогтохын “Хамниган монгол аялгуун дахь

дундад эртний монгол хэлний үлдэгдэл, онцлог” гэдэг өгүүллүүд Улаанбаатар хотноо, 2017 онд Эрдэнэтогтохын “Мэргэлийн хамниган эвенкчүүд ба түүний монгол хэл, аялгууны тухай” хэмээх өгүүлэл Хөх хотноо нийтлэгдэн гарчээ.

4.2. Орчоон хэл, түүний аялгуунууд

Орчоон хэл нь эвенк хэлний солоон аялгуутай маш ойр төстэй байдаг нь нэг үндэстэн байсныг баталдаг.

Орчоон хэлний үгийн сан ан агнуурын үг хэллэгээр баялаг. Жишээ нь: *бор гөрөөс*-ийг [kiwʃøŋ] – кивчөн гэх бөгөөд эрийг [qora:ŋ] – *кураан*, эмийг [kə:raja] – *коораяа*, нэг настайг [intʃkʰəŋ~jəntʃkʰəŋ] – *инжкэн~янжкан*, хоёр настай эрийг [ʃinʃa:wlə] – *шиншаавлэ*, хоёр настай эмийг [kʰuikʰwa:] – *күйква* гэж нас хүйсээр нь ялган нэрлэдэг байх жишээтэй.

Хөлөнбуйр хотын Орчоон үндэсний өөртөө засах хошуунд төвлөрөн суусан орчоончууд өдгөө 60000 гаруй хүн амтай боловч орчоон хэлний хүрээ хэмжээ маш ихээр багасжээ. Өдгөө 50-60 насны орчоончууд нийтлэг ярьж байхад 40-50 насныхан бага сага мэддэг, түүнээс доош насны залуучууд, багачууд хэлээ мэдэхгүй болж, хятад үг хэл, үсэг бичиг хэрэглэж байна. Тийнхүү зөвхөн настайчууд нь хошуу, сумандаа ярилцдагийг эс тооцвол нийтлэг хятад хэлтэн болж, орчоон хэл нийгмийн амьдралаас таягдах аюултай хэл болоод байна.

Орчоон хэлийг судлах ажил 1980-аад оноос эхэлсэн бөгөөд Дундад улсын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн эрдэмтэн Хөү Чен И нутагт нь очиж тусгайлан судалж, О.Цогтой хамтран “Орчоон хэлний товч тэмдэглэл” бичиж хэвлүүлжээ. Дараа нь тэрээр “Орчоон хэлний судлал” нэг сэдэвт бүтээл хэвлүүлж, О.Цог бас өгүүллүүд нийтлүүлсэн билээ.


5. Судалгааны үр дүн

Дурдсан хэл, аялгуутнууд Хөлөнбуйр хотын аль хэсгээр нутагладгийг газрын зурагт тэмдэглэж харуулъя. Үүнд:

Хүснэгт 1. Хөлөнбуйр хот дахь монгол төрөл хэлтэн хийгээд манж-түнгүүс төрөл хэлтний байршил

Ба	Өмнөд монгол хэлний барга аялгуу	Хуучин барга хошуу, Шинэ барга баруун хошуу, Шинэ барга зүүн хошуу
Бу	Өмнөд монгол хэлний буриад аялгуу	Эвенк үндэсний өөртөө засах хошууны Шинэхэн баруун, Шинэхэн зүүн, Мөнгөнчулуу сум
Өө	Өмнөд монгол хэлний өөлд аялгуу	Эвенк үндэсний өөртөө засах хошууны Имин сум
Да	Дагуур хэл	Морин даваагийн дагуур үндэсний өөртөө засах хошуу, Эвенк үндэсний өөртөө засах хошууны Баянтал сум, Баянтохой балгас, мөн Хайлаар хотод цөөн
Эв	Эвенк хэл	Эвенк үндэсний өөртөө засах хошууны Хой, Имин, Баянцагаан сумд, Баянтохой балгас, Гэгээнгол хотын Олгуйяа эвенк сум
Ор	Орчоон хэл	Орчооны өөртөө засах хошуу

БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөлөнбуйр хотод амьдардаг монгол ба манж-түнгүүс үндэстний хэлнүүд болох монгол төрөл – өмнөд монгол ба дагуур хэл, манж-түнгүүс төрөл – эвенк ба орчоон хэл бүгд алтай хэлний язгууртай болохоор өөр хоорондоо тодорхой хэмжээгээр ижил төстэй тал ажиглагддаг. Эдгээр хэл өөр хоорондоо адилсах явдал ч түгээмэл. Гэвч өдгөө бүгд хятад хэлний нөлөөг хүртэж, зарим хэсэг нь уугуул хэлээ мартаж, ялангуяа хүүхэд залуус нь хятад хэлтэн болж байна. Өнөөгийн байдлаар орчоон хэл устаж мөхөх шатандаа орсон байна. Нөгөө талаас, урт удаан хугацаанд энэхүү нутаг усанд холилдон амьдарсан боловч өөрийн хэл, аялгууныхаа онцлог шинжийг өнөө хэр ямар нэг хэмжээгээр хадгалж буй нь ч бас байна. Тухайлбал өөлд хүмүүс цөөхөн, хэл яриа нь мөн л бусад хэл, аялгуунд ууссан зүйл олон байвч өнөө хэр бусдаасаа ямар нэг байдлаар заавал ялгарч мэдэгддэг. Ийм аялгууг цаг алдалгүй судлан шинжлэх нь чухал бөгөөд сонирхолтой юм.



Зураг 1. Хөлөнбуйр хот дахь монгол төрөл хэлтэн хийгээд манж-түнгүүс төрөл хэлтний байршил

6. Дүгнэлт

БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөлөнбуйр хотод аж төрж байгаа монгол төрөл хэлтэн (өмнөд монгол хэлний барга-буриад ба өөлд аялгуу, дагуур хэлний хайлаар ба будха аялгуу), манж-түнгүүс төрөл хэлтэн (эвенк ба орчоон) нь удаан хугацаанд нэг нутагт айлсан холилдон амьдарч, ахуй амьдрал, хэл соёлынхоо талаар харилцан нягт холбоотой байсны нөлөөгөөр эх хэлнийхээ уугуул шинжээс ихээхэн холдож, нөлөөлсөн хэлнийхээ шинжид ахиухан ойртсон байна. Хэдий тийм боловч хэл тус бүр нь өөр өөрийн гэсэн өвөрмөц шинжийг бага боловч хадгалж байна. Цаашид нарийвчлан судлах хүмүүст суурь ойлголт, чиг баримжаа болохын үүднээс энэхүү тойм өгүүллийг бичлээ.

Ном зүй

- Батзаяа, Г.** (2020). *Монгол хэл, аялгуунуудын нэр, үйл үгийн холбох нөхцөлийн харьцуулсан судалгаа*. Улаанбаатар: Арвай принт. [Batzaya, G. *Mongol khel, ayalguunuudyn ner, үйл үгийн kholbokh nökhötsöliin haritsuulsan sudalгаа* [A comparative study of the inflectional affix of nouns and verbs in Mongolian languages and dialects]. Ulaanbaatar: Arvai print. 2020.]
- Батзаяа, Г.** (2022). *Монгол хэл, аялгуунуудын нэр, үйл үгийн төгсгөх нөхцөлийн харьцуулсан судалгаа*. Улаанбаатар: Арвай принт. [Batzaya, G. *Mongol khel, ayalguunuudyn ner, үйл үгийн tögsgökh nökhötsöliin haritsuulsan sudalгаа* [A comparative study of the final affix of nouns and verbs in Mongolian languages and dialects]. Ulaanbaatar: Arvai print. 2022.]
- Батзаяа, Г., Отгончимэг, Б., Бай, Тулгуур.** (2024). *Монгол хэлний нутгийн аялгуу, төрөл хэлний ном зүйн бүртгэл*. Улаанбаатар: Арвай принт. [Batzaya, G., Otgonchimeg, B., Bai, Tulguur *Mongol khelnii nutgiin ayalguu, töröl khel sudlalyn nom züin bürtgel* [Bibliography of the Mongolian Dialects and Related Languages]. Ulaanbaatar: Arvai print. 2024.]
- Ринчен, Б.** (1969). *Монгол ард улсын хамниган аялгуу*. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэл. [Rinchen, B. *Mongol ard ulsyn khamnigan ayalguu* [Khamnigan dialect of Mongolia]. Ulaanbaatar: Academy of Sciences Press. 1969.]
- Санжаа, Ж., Надмид, Ж.** ([1993], [2008] 2018). *Монгол хэлний авиазүй ба авиалбарзүй*. Улаанбаатар. [Sanjaa, J., Nadmid, J. *Mongol khelnii avia züi ba avialbar züi* [Phonetic and Phonology of Mongolian language]. Ulaanbaatar. 2018.]
- Сэнгэ, Наранчимэг.** (2018). *Senge, Narančimeg. Öbür Mongγol-un mongγol kelen-ü nutuy-un ayalun-u yaǰar-un jiruy-un bayičaγalta-yin material-un čubural (Kölinbuyir qota-yin boti)*. Kökeqota: Öbür Mongγol-un suryan kümüjil-ün keblel-ün qoriy-a. [Senge, Narančimeg. *Övör Mongolyn mongol khelnii nutgiin ayalguuny gazryn zurgin baitsaaltyn material* [Research materials for the Linguistic map of Dialects of the Mongolian language in Inner Mongolia]. Höhhot: Educational Press Committee. 2018.]
- Сэндмаа, Ж.** (2011). *Sendem-a. Qamniyan ewenki sudulul*. Kökeqota: Arad-un keblel-ün qoriy-a. [Sendmaa, J. *Khamnigan evenk sudlal* [Studies on the Khamnigan Evenki]. Höhhot: People's Press Committee. 2011.]
- Сэцэнбаатар.** (2005). *Sečenbaatur. Mongγol kelen-ü nutuy-un ayalun-u sinjilel-ün uduridqal*. Kökeqota: Arad-un keblel-ün qoriy-a. [Setsenbaatar. *Mongol khelnii nutgiin ayalguuny шинжлелин удиртгал* [Introduction to the Study of Mongolian dialects]. Höhhot: People's Press Committee. 2005.]
- Төмөртоогоо, Д. Төмөртоогоо, Д.** (2023). *Монгол хэлний хөгжлийн түүх*. Улаанбаатар. [Tömörtogoo, D. *Mongol khelnii Khögjliin түүх* [History of the Development of Mongolian language]. Ulaanbaatar. 2023.]
- Төмөртоогоо, Д.** (2017). *Монгол хэлний түүхэн авиа зүйн үндэс*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Tumurtogoo, D. *Mongol khelnii түүхэн авиа зүйн үндэс* [Principles of the Historical Phonology of Mongolian]. Ulaanbaatar. 2017.]
- Хас-Эрдэнэ.** (2014). *Qaserdeni. Qaserdeni-yin jokiyaal бүтүгел-үн чигүүлэн 4: Дагур келе ба монгол келен-ү қарічаулул* Тунляо хот: Жирим үндэстний хэвлэх бүрэн бус компани. [Khas-Erdene. *Khas-Erdeniin zokhiol бүтеелиин чуулган 4: Daguur khel ba mongol khelnii kharitsuulal* [A comparative study of the Dagur language and Mongolian language]. Tunlyoo: Printing compani. 2014.]